

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Монложистикс Холдинг ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “**Хурал**” гэх) 2024 оны 4-р сарын 27-ны өдрийн 14 цаг 00 минутад эхлэв. Хурлыг БиДиСек ҮЦК ХК-ийн хөгжүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг Лайстрийм ХХК-ийн тусламжтайгаар хурлын платформуор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар хүргэв.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “**ТУЗ**” гэх)-ийн нарийн бичгийн дарга бөгөөд Хурал зохион байгуулах комиссын дарга Ц. Дуламсүрэн хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчидтэй мэндчилэн, хуралд оролцогчдыг танилцуулсаны дараа хурлын дэгийг танилцуулан хурлыг эхлүүлэв.

Хуралд биечлэн оролцсон:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г. Хишигбат
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг
3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог

Хурлын тооллогын комисс:

1. Комиссын дарга, Дотоод аудитор Б.Тамжиддорж
2. Комиссын гишүүн, санхүүгийн шинжээч Б.Амарбаясгалан
3. Комиссын гишүүн, нягтлан бодогч Н. Дэлгэрцэцэг

Хурлын нарийн бичгийн дарга:

1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ц. Дуламсүрэн

Хурлын дэгийн дагуу Тооллогын комиссын дарга Б. Тамжиддоржийг хурлын ирцийг танилцуулахыг хүсэв.

Хурлын ирц: Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргахад нийт хуралд оролцох эрхтэй 388,538,822 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 1309 хувьцаа эзэмшигч байснаас хуралд 332,456,804 ширхэг энгийн хувьцаа бүхий 42 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц 85.57 хувь болж байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож байгааг Хурлын даргад мэдээлэв.

Ирц бүрдсэн тул компанийн Хурлын дарга Г. Хишигбат хурлыг нээж үг хэлэн, хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн ТУЗ-ийн цалингийн төсвийг хэлэлцэж батлах.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Танилцуулсан нь:

Хурлын дарга Г. Хишигбат компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангаас онцлох тоон үзүүлэлтүүд, үйл ажиллагааг танилцуулав. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайланг танилцуулахдаа ОХУ-ын дайны нөхцөл байдал, гадаад орчны хүндрэл, эдийн засаг, хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүдээс шалтгаалан вагон худалдан авах ажиллагааг урт хугацаанд бага багаар, үе шаттайгаар хэрэгжүүлэх, энэ шалтгаанаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг өөр боломжит төслүүдэд зарцуулах төлөвлөгөөтэй байгааг тухай хувьцаа эзэмшигчиддээ мэдээлэл өгөв. Хурлын дарга Г. Хишигбат компанийн 2023 оны санхүүгийн тайланг танилцуулсаны дараа хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцав.

Хурлын дарга Г. Хишигбат 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи “Монложистикс Холдинг” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийж ажилласан “Грант Торнтон” ХХК-ийн Хараат бус аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.”, “Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй” гэсэн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулав.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2024 оны цалингийн төсвийг хэлэлцэж батлах;

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг ТУЗ-ийн 2023 оны тайланг танилцуулав.

Хурлын дарга Г. Хишигбат ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын талаар Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гаргасан саналыг танилцуулж, ТУЗ-ийн гишүүдэд үндсэн цалин болон хорооны дарга, хорооны гишүүний нэмэгдэл цалин олгохоор цалингийн төсвийг батлуулах санал оруулж буйг танилцуулав.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт хариулт:

- | | | | |
|------------|----------|----|------------|
| 1. Хувьцаа | эзэмшигч | Г. | Отгонцэцэг |
|------------|----------|----|------------|

- Монложистикс группийн танилцуулга дээр cheerah гээд брэнд байна. Cheerah нь Монложистикс групптэй ямар хамааралтай вэ?

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

Монложистикс Холдинг компанийн 100% хөрөнгө оруулалттай Монложистикс Карго ХХК нь 2021 онд үүсгэн байгуулагдсан. Үндсэн үйл ажиллагаа нь олон улсын e-commerce үйлчилгээг үзүүлэхдээ sheerah гээд брэндээр дамжуулан явуулдаг. Хятадын хамгийн том цахим худалдааны Tmall, Taobao сайтуудтай холбогдож ажилладаг.

2. Хувьцаа эзэмшигч М. Хосбаяр

- Вагон худалдаж авах юу болж байгаа вэ? ОХУ дайнтай байгаатай холбоотой худалдан авалт хэр хүндрэлтэй байгаа вэ?

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

Энэ асуудлыг түрүүн үйл ажиллагааны тайлан дээрээ тодорхой тайлбарласан. Бид 100 вагон худалдан авах төлөвлөгөөтэй, гэхдээ ОХУ-ын дайны болон бусад гадаад хүчин зүйлс, нөхцөл байдал хүндэрчихгүй бол цөөн цөөн ширхэгээр худалдан авч, 2026 он гэхэд нийт 100 вагонаа авна гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

3. БиДиСек үнэт цаасны компаниас:

- Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрхэн яаж хийж байгаа вэ?

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

Монложистикс групп 2023 онд ESOP хөтөлбөрийг судалж, сонгодог утгаар нь хэрэгжүүлэхээр Monlogistics future гэдэг хаалттай хувийн сан байгуулж, уг сангаараа дамжуулан үйл ажиллагаа явуулж байна, сангийн нэгж эрхтэй эзэмшигчид нь ESOP хөтөлбөрт хамрагдаж байгаа компанийн ажилтнууд байна. ESOP хөтөлбөрт хамрагдсан ажилтан цалингаасаа 5%-ийг санд төвлөрүүлнэ, компани мөн ажилтны цалинтай тэнцэх хөрөнгийг төвлөрүүлж, сангийн хөрөнгийн 70%-иар Монложистиксийн хувьцааг худалдан авч, 30% урт хугацаат бонд болон money market дээрээс хувьцаа, бонд зэргийг худалдан авдаг, сангийн үйл ажиллагааг Ашид ассет менежмент ҮЦК, Голомт кастодиан хариуцан ажиллаж байна.

4. Хувьцаа эзэмшигч Жавзансүрэн Пүрэвжав

- Ногдол ашгийг хэзээнээс өгөхөөр төлөвлөж байгаа вэ?

2023 оны санхүүгийн жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 7,58 (долоон төгрөг тавин найман мөнгө) төгрөгөөр тогтоож, Компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 3,000,609,870.76 (гурван тэрбум зургаан зуун есөн мянга найман зуун далан төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилна. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан тушаалын дагуу “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр олгоно.

Санал өгөх зааврыг Хурал зохион байгуулах комиссын дарга Ц. Дуламсүрэн танилцуулж, санал хураалтын 10 минут эхэлснийг мэдэгдэв.

Санал өгөх болон тоолох хугацаа нийт 15 минут үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Б. Тамжиддорж Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар танилцуулав. Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. “Монложистикс Холдинг ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх” асуудлаар санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
331,634,896	100%	0	0%	0	0%
Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5-д заасны дагуу шийдвэр 100 хувиар хүчинтэй.					

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны цалингийн төсвийг хэлэлцэж, шийдвэрлэх асуудлаар санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
331,634,896	100%	0	0%	0	0%
Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5-д заасны дагуу шийдвэр 100 хувиар хүчинтэй.					

Хурлын дарга Г. Хишигбат санал хураалтын дүнтэй танилцаад хурлаас дараах шийдвэрүүд гарсан тухай танилцуулав. Үүнд:

Шийдвэр 1: “Монложистикс Холдинг” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлав.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монложистикс Холдинг” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

Шийдвэр 2: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Монложистикс Холдинг” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10.5 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн

2024 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хурлын дарга хурлыг хааж үг хэлэв.

Хурал 15 цаг 45 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга



Ц. Дуламсүрэн

Хянасан:

Хурлын дарга



Г. Хишигбат